



“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр

№ 2024/01

Улаанбаатар хот

“Улаанбаатар БҮК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 11 цаг 10 минутанд “Улаанбаатар БҮК” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэл 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 11:00 цаг хүртэл явагдаж дуусав.

Хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Нямхүү даргалав.

Тооллогын комисс-д Д. Пүрэвцэрэн, Л. Билгүүн, Д.Ууганцэцэг нар тус тус ажиллав.

Мөн хуралд Гүйцэтгэх захирал Х.Золжаргал оролцов.

Хурлын ирц:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт 131 5 47 500 ширхэг саналын эрхтэй хувьцааны 128,316,055 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 97,54 хувийг төлөөлсөн 7 хувьцаа эзэмшигч оролцсон тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу “ирцийг хүчин төгөлдөрт тооцох” талаарх Тооллогын комиссын шийдвэрийг Комиссын дарга Д. Пүрэвцэрэн хуралд оролцогсдод танилцуулав.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1. Башир Мухамед /”Улаанбаатар менежмент” ХХК-ийн итгэмжлэлээр/
Хувьцааны тоо: 128 315 700
2. Даваажав овогтой Энхтуяа
Хувьцааны тоо: 110
3. Сумьяа овогтой Уранчимэг
Хувьцааны тоо: 9
4. Мягмаржав овогтой Шигшээ
Хувьцааны тоо: 11
5. Сандагжав овогтой Дашдорж
Хувьцааны тоо: 75
6. Баттөмөр овогтой Ганболд
Хувьцааны тоо: 100
7. Пунцаг овогтой Цогзолмаа
Хувьцааны тоо: 50

Хэлэлцэх асуудал:

1. **Хэлэлцэх асуудал-1:** 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай;
2. **Хэлэлцэх асуудал-2:** “Улаанбаатар БҮК” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;

3. Мэдээлэл өгөх: Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах ;

4. Мэдээлэл өгөх: “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар танилцуулах

5. Хэлэлцэх асуудал-3: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг батлах;

6. Хэлэлцэх асуудал-4: ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төсөв батлах;

Хурлын дарга Д.Нямхүү ээлжит хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулсныг Хувьцаа эзэмшигчид батлав.

Хурал даргалагч Д.Нямхүү Тооллогын комиссын тогтоолын шийдвэрийг танилцуулж , хурлын ирц 97.54 хувийн дүнтэй байгаа тул хурлыг нээснийг мэдэгдэв.

Хэлэлцэх асуудал-1:

2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай;

“Улаанбаатар БҮК” ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Гүйцэтгэх захирал Х. Золжаргал дараах байдлаар танилцуулав.

Санхүүгийн үзүүлэлтүүд, 2023 оны жилийн эцсийн орлого, үр дүнгийн тайлангаар

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжээх нэгж	2019	2020	2021	2022	2023 төсөв	2023 гүйцэтгэл	Төсвийн биелэлт %
А	Б	1	2	3	4	5	6	6/5
ҮЙЛДВЭРЛЭЛ								
Үүнээс: Метал хийц	тонн	122.5	275	146.22	283	300	265	88%
ТБХЭ	м²	11,841	9,345	10,331.60	12,188	15,217	17,716.0	116%
ТЗ-ТБ дэр	м²	10,328	46,227	21,145.60	30,012	12,281	5,583.0	46%
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	19,448	65,612	39,167	72,085	50,470	37,055	73%
Үүнээс: Метал хийц	сая.төг	88	235	-	374	1,000	56.4	6%
ТБХЭ	сая.төг	6,530	3,914	7,526.70	14,024	19,800	16,417	83%
ТЗ-ТБ дэр	сая.төг	11,938	60,742	31,419	58,441	29,870	19,850	66%
Бусад элдэв	сая.төг		721	221	1,246		931	
ББӨ	сая.төг	12,682	39,546	23,616	52,895	31,798	21,259	67%
ББӨ орлогод эзлэх хувь	хувь	66.4%	60%	60%	73%	63%	57.37%	91%
НИЙТ АШИГ	сая.төг	6,415	26,335	15,551	19,390	18,674	15,639.3	84%
Нийт ашгийн хувь	Хувь	33.60%	40%	40%	27.00%	37.00%	42.38%	115%
БУЗ	сая.төг	4,229	10,172	12,351	15,739	14,366	15,123	105%
БУЗ/Орлого %	хувь	23%	16%	32%	22%	28%	41%	146%
ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	сая.төг	2,485	12,567	3,220	2,340	4,318	377	9%
Цэвэр ашгийн хувь	хувь	12.90%	19%	8.20%	3.20%	8.6%	1%	12%
Нэгж хувьцанд ногдох ЦА	төг	18.74	95.53	24.5	17.79	32.81	2.8	9%
АЖИЛЧИД, ДУНДЖААР	хүн	152.4	257.3	267	308.2	309	279	90%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	-	5,049	2,922	2,950	6,827	2,876	42%

Асуулт, санал хариулт:

Хувьцаа эзэмшигч Г.Ганболдын одоогийн том хөрөнгө оруулалт, түүнчлэн “Оюу толгойн төсөл”-ийн явц байдлын талаар асуусан асуултад Гүйцэтгэх захирал Х.Золжаргал тус компани нэмэлтээр жижиг бетон эдлэлийн үйлдвэрт зориулж 7-р порлётын барилгын ажил

явагдаж байгаа ба 2025 оны эхээр шинэ үйлдвэр ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна, мөн нэмээд гүний дулааны шугамын захиалга яригдаж байгаа талаар хариулт тайлбар өгөв.

Хувьцаа эзэмшигч М.Шигшээ, 2024 оны 1-р улирлын тайлангийн үр дүнгийн талаар асууж лавласан ба Гүйцэтгэх захирал Х.Золжаргал 1-р улирлын үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явагдаж тайлан хийгдсэн талаар мэдээлэв.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа менежментийн зөв бодлогоор ажиллаж байгаад Компанийн удирдлагад амжилт хүсэж байгаагаа илэрхийлэв.

Дээрх асуудлаар өөр асуулт, санал гараагүй тул компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх “хангалттай” гэж ТУЗ дүгнэснийг батлах талаар санал хураалт явуулав.

Санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн танилцуулав.

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 0

Санал хураалтын дүн: 100%

ШИЙДВЭР:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг “хангалттай” гэж батлах.

Хэлэлцэх асуудал-2:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай ТУЗ-ийн саналыг Д.Нямхүү танилцуулж санал хураалт явуулав.

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 0

Санал хураалтын дүн: 100%

ШИЙДВЭР:

1. “Улаанбаатар БҮК” ХК-ийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулах саналыг батлах. Үүнд:

1. Компанийн дүрмийн 7.54 дэх заалтад:

7.54. “ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Үйлдвэрлэл эрхэлсэн захирал, ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий инженер зэрэг Гүйцэтгэх захирлын удирдлагын багийн гишүүдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно”

2. Компанийн дүрмийн 7.2 дахь заалтад:

7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

3. Мөн “Аудитын хороо” гэснийг “Аудит эрсдлийн хороо” гэж өөрчлөн дүрэмд тусгах

Мэдээлэл өгөх : Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;

Компанийн ТУЗ-өөс 2023 онд нэгж хувьцааны ногдол ашгийг 1 төгрөгөөр тооцож нийт 131 547 500 төгрөгийн ногдол ашгийг 6 дугаар сарын 1-ний дотор тараах шийдвэр гаргасныг Хурал даргалагч Д.Нямхүү уншиж танилцуулав.

Хэлэлцэх асуудал-3: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг батлах;

ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай:

Хурал даргалагч Д.Нямхүү ТУЗ-д 9 хүнийг нэр дэвшүүлэхээр Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан шийдвэрийг, тэдгээр гишүүдийн танилцуулгын хамт танилцуулав.

ТУЗ-д нэр дэвшүүлсэн гишүүдэд куммулятив аргаар санал хураасан дүнг Тооллогын комиссын дарга Д. Пүрэвцэрэн танилцуулав.

ШИЙДВЭР:

1. “УЛААНБААТАР БҮК” ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр дараах нэр бүхий хүмүүсийг үргэлжлүүлэн томилох:

Ердийн гишүүд:

1. Д.Нямхүү
2. Д.Мөнхөө
3. Х.Золжаргал
4. Х.Ю.Хамхоев
5. О.Басанхүү
6. М.А.Чапанов

Хараат бус гишүүд

1. С.Б.Громов
2. Г.Цогнэмэх
3. Ч.Энхбат

Мэдээлэл өгөх: “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2024 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар танилцуулах тухай;

Гүйцэтгэх захирал Х. Золжаргал “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2024 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн талаар дараах мэдээллийг танилцуулав.

Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөв байдал

--	--	--	--	--	--	--	--	--

Хүрээ / Перспектив	<u>Гүйцэтгэлийн Түлхүүр Үзүүлэлт[1]</u>	Хэмж их нэгж	2019	2020	2021	2022	2023	2024: хү рэх түвшин
Ашиг, орлого	Борлуулалтын орлого	Тэрбум төг	19,449	65,612	39,167	72,085	37,055	58,834
	Ашгийн марж	Хувь	33.60%	40%	40%	27%	42%	41.1%
	Нэгж хувьцаанд ногдох ЦА	Төгрөг	18.74	95.53	23	17.79	2.8	66.79
	Хөрөнгийн өгөөж (ROA)	Хувь	6%	23%	5%	3%	1%	15%
Хэрэглэгч, зах зээл	ТБХЭ-н зах зээлд эзлэх	Хувь	-	30%	16.6%	19%	23%	24%
	Зах зээлд гаргаж борлуулах шинэ бүтээгдэхүүн	ТШ: төл. биелэлт	1бүт: 100%	2бүт: 100%	6бүт: 88%	4бүт: 79%	4бүт: 73%	6 бүт: 95%
	Хэрэглэгчийн сэтгэл ханамж	Хувь	-	79%	85%	87%	85%	88%
Бизнес процесс, үйл ажиллагаа	Бүтээгдэхүүний чанар	Хувь	-	99.70%	99.50%	99.75%	99.30%	99.75%
	Бүтээмж: ТБХЭ/Хүний тоо	МЗ	361.5	511	275.7	321.3	273	308
	Бүтээмж: Метал/Хүний тоо	тонн	7.78	10.38	6.07	10	12	15

нөөцийн удирдлага	Бүтээмж: Орлого/Хүн ий тоо	Сая төг	127.6	255	147	235	133	198
	Ажилтнууд ын гүйцэтгэлийн н дундаж үнэлгээ	Хувь	-	-	-	-	-	> 80%

2024 оны жилийн зорилтууд

2024 онд стратегийн зорилт/чиглэлийн хүрээнд тулгамдаж буй асуудал, тэргүүлэх чиглэлийг шийдвэрлэхээр алба нэгж, бүтээгдэхүүний түвшинд дараах зорилт, тодорхой үр дүнг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

Стратегийн чиглэл 1: Том бүтээн байгуулалтад оролцоогоо нэмэгдүүлж бизнесийн өсөлт, ашигт ажиллагааг сайжруулна

Стратегийн чиглэл 2: Хэрэглэгчид хүргэх үнэ цэнийн сайжруулалтад төвлөрч зах зээлийн нэр хүнд, тэргүүлэгч байр сууриа бэхжүүлэх

Стратегийн чиглэл 3: Үйл ажиллагааг стандартад нийцүүлж бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, үр ашиг сайжруулах, аюулгүй ажиллагааг хэвшүүлэх

Стратегийн чиглэл 4: Үйлдвэрлэлийн хүчин чадал, техник технологи, менежментийн тогтолцоо, хүний нөөцийг хөгжүүлэх замаар байгууллагын чадавхийг бэхжүүлэх

Хэлэлцэх асуудал-4: ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төсөв батлах;

Д.Нямхүү ТУЗ-ийн үйл ажиллагааны 2024 оны төсвийн талаар тодорхой тайлбар хийж батлах талаар санал хураалт явуулав.

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 0

Санал хураалтын дүн: 100%

ШИЙДВЭР:

1. Компанийн 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг **357,324,000** / гурван зуун тавин долоон сая гурван зуун хорин дөрвөн мянган / төгрөгөөр батлах

Хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурал хаасныг Хурал даргалагч Д.Нямхүү мэдэгдэв.

Хувьцаа эзэмшигчдийн хурал 15.00 цагт дуусав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Комиссын гишүүн: *Д. Ууганцэцэг* Д.Ууганцэцэг